



ХЭНТИЙ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

23119 Хэнтий аймаг, Хэрлэн сум, Сариг баг
Утас: 70-56-21-12, Факс: 70-56-21-12
E-mail: khentii@audit.gov.mn

2024.07.29 № 692

танай _____ -ны № _____ -т

Г ХЭНТИЙ АЙМГИЙН БАЯНМӨНХ СУМЫН 1
ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН
ЭЭЛЖИТ СОНГУУЛЬД ОРОЛЦОХ
БАЯНМӨНХ СУМЫН МАН-ЫН ХОРООНЫ
ДАРГА Б.ЗОЛЖАРГАЛ ТАНАА

Г Сонгуулийн мөрийн хөтөлбөр хуульд 1
заасан шаардлагад нийцсэн талаарх
дүгнэлт

Төлөөлөгчдийн Хурлын сонгуулийн тухай хуулийн 37 дугаар зүйлийн 37.5, Хөгжлийн бодлого, төлөвлөлт, түүний удирдлагын тухай хуулийн 5.4-т заасан Үндэсний аудитын газрын бүрэн эрхийн хүрээнд 2024 оны Аймаг, нийслэл, сум, дүүргийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын ээлжит сонгуулийн тухай хууль, Төсвийн тогтвортой байдлын тухай хууль, Хөгжлийн бодлого, төлөвлөлт, түүний удирдлагын тухай хууль болон Монгол Улсын Үндэсний аюулгүй байдлын үзэл баримтлал, "Алсын хараа-2050" Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлого, УИХ-аас баталсан хөгжлийн бодлого, төлөвлөлтийн баримт бичигт нийцүүлэн боловсруулж, санхүүгийн тодорхой эх үүсвэр шаардсан зорилт, арга хэмжээг хэрэгжүүлэхэд шаардагдах зардлын талаарх тооцоо, судалгааг гарган хуульд заасны дагуу дүгнэлт гаргуулах үүрэг хүлээнэ.

Үүрэг хариуцлагын талаарх мэдээлэл

2024 оны аймаг, нийслэл, сум, дүүргийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын ээлжит сонгуульд оролцох нам, эвсэл болон бие даан нэр дэвшигч нь сонгуулийн мөрийн хөтөлбөрөө Аймаг, нийслэл, сум, дүүргийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын ээлжит сонгуулийн тухай хууль, Төсвийн тогтвортой байдлын тухай хууль, Хөгжлийн бодлого, төлөвлөлт, түүний удирдлагын тухай хууль болон Монгол Улсын Үндэсний аюулгүй байдлын үзэл баримтлал, "Алсын хараа-2050" Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлого, УИХ-аас баталсан хөгжлийн бодлого, төлөвлөлтийн баримт бичигт нийцүүлэн боловсруулж, санхүүгийн тодорхой эх үүсвэр шаардсан зорилт, арга хэмжээг хэрэгжүүлэхэд шаардагдах зардлын талаарх тооцоо, судалгааг гарган хуульд заасны дагуу дүгнэлт гаргуулах үүрэг хүлээнэ.

Сонгуулийн мөрийн хөтөлбөрийн дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага нь 2024 оны аймаг, нийслэл, сум, дүүргийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын ээлжит сонгуульд оролцох нам, эвсэл болон бие даан нэр дэвшигчийн сонгуулийн мөрийн хөтөлбөрийг хянан үзэхдээ Төрийн аудит MNS 6817 - 1:2020 Төрийн аудит. Тулгуур зарчим, MNS 6817 - 6:2020 Төрийн аудит. Нийцлийн аудитын зарчим, MNS 6817 - 8:2020 Төрийн аудит. Нийцлийн аудит стайндартыг удирдлага болгон Аймаг, нийслэл, сум, дүүргийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын ээлжит сонгуулийн тухай хууль, Төсвийн тогтвортой байдлын тухай хууль, Хөгжлийн бодлого, төлөвлөлт, түүний удирдлагын тухай хууль болон Монгол Улсын Үндэсний аюулгүй байдлын үзэл баримтлал, "Алсын хараа-2050" Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлого, УИХ-аас баталсан хөгжлийн бодлого, төлөвлөлтийн баримт бичиг, Монгол Улсын нэгдсэн төсвийн 2024 оны төсвийн хүрээний мэдэгдэл, 2025-2026 оны төсвийн төсөөллийн тухай

232420719

хууль, холбогдох байгууллагаас авсан тайлан, судалгаа, мэдээллийг тус тус шалгуур болгон авч үзсэн.


Дүгнэлт

Хэнтий аймгийн Баянмөнх сумын МАН-ын хорооны аймаг, нийслэл, сүм, дүүргийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2024 оны ээлжит сонгуульд оролцохоор ирүүлсэн сонгуулийн мөрийн хөтөлбөрийн зорилт, арга хэмжээ нь Аймаг, нийслэл, сүм, дүүргийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын ээлжит сонгуулийн тухай хуулийн 37 дугаар зүйлийн 37.3 дахь хэсэг, Хөгжлийн бодлого, төлөвлөлт, түүний удирдлагын тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.3 дахь хэсэг, Төсвийн тогтвортой байдлын тухай хуульд заасан тусгай шаардлагад тус тус нийцсэн байна.

Хэнтий аймгийн Баянмөнх сумын МАН-ын хорооны мөрийн хөтөлбөр (6 хуудас)-ийг хавсаргав.

Хувийг: Хэнтий аймгийн Баянмөнх сумын Сонгуулийн хороонд.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Ж.ГАНБААТАР

ХЯНАСАН:


АУДИТЫН МЕНЕЖЕР



Д.ОЮУНТУЯА


БОЛОВСРУУЛСАН:

АХЛАХ АУДИТОР



Д.ЭРДЭНЭБИЛЭГ

АУДИТОР



Ц.ХАТАНБОЛД



**ХЭНТИЙ АЙМГИЙН МОНГОЛ АРДЫН НАМЫН 2024 ОНЫ АЙМГИЙН ИРГЭДИЙН
ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН СОНГУУЛЬД ОРОЛЦОХ МӨРИЙН ХӨТӨЛБӨР**


АГУУЛГА.

**НЭГ. ЭДИЙН ЗАСГИЙН ӨСӨЛТИЙГ ӨРХ БҮРТ ХҮРГЭХ ХҮНИЙ ХӨГЖЛИЙН
БОДЛОГО**

- 1.1. Орон сууц
- 1.2. Эрүүл мэнд
- 1.3. Боловсрол
- 1.4. Халамж, хөдөлмөр эрхлэлт
- 1.5. Үндэсний бахархал, өв соёл, спорт
- 1.6. Хүүхэд гэр бүлийн хөгжил

ХОЁР. ЭДИЙН ЗАСГИЙН БОДЛОГО

- 2.1. Хөдөө аж ахуй
- 2.2. Аялал жуулчлал
- 2.3. Дэд бүтцийн сүлжээ
 - 2.3.1. Эрчим хүчний төсөл
 - 2.3.2. Агаарын тээвэр
 - 2.3.3. Авто зам



ГУРАВ. НОГООН ХӨГЖЛИЙН БОДЛОГО

ДӨРӨВ. ИРГЭДИЙН ОРОЛЦООНД ТУЛГУУРЛАСАН ЗАСАГЛАЛЫН БОДЛОГО

ТАВ. ОРОН НУТГИЙН ХӨГЖЛИЙН БОДЛОГО

НЭГ. ЭДИЙН ЗАСГИЙН ӨСӨЛТИЙГ ӨРХ БҮРТ ХҮРГЭХ ХҮНИЙ ХӨГЖЛИЙН БОДЛОГО

1.1. Орон сууц

1.1.1. Хувийн хэвшилтэй түншлэн 24 айлын орон сууцийг байрьж ашигалалтанд оруулна.

1.2. Эрүүл мэнд

1.2.1. Хүн амын дундаж наслалтыг нэмэгдүүлэх хүрээнд эрүүл мэндийн үзлэгийг тасралтгүй үргэлжлүүлж, дундаж наслалтын хүйсийн ялгаатай байдлыг багасгах бодлого хэрэгжүүлнэ.

1.2.2. Өвчнөөс урьдчилан сэргийлэх, эрт мэдээлэх, сануулах хиймэл оюун ухаанд суурилсан системийг хөгжүүлж, салбарын цахим шилжилтийг эрчимжүүлэн эрт илрүүлгийг нэмэгдүүлнэ.

1.2.3. Эрүүл амьдралын хэв маягийг дэмжсэн дасгал хөдөлгөөн, спорт, нийтийн биеийн тамираар хичээллэх, эрүүл, зөв хооллох, өвчнөөс урьдчилсан сэргийлэх нийгмийн эрүүл мэндийн тогтолцоог бэхжүүлнэ.

1.2.4. Хүний нөөцийг чадавхжуулах арга хэмжээг чиглэл бүрээр зохион байгуулж, ур чадварыг нэмэгдүүлэх, гадаад болон дотоодод туршлага судлуулна.

1.2.5. “Элэг бүтэн Монгол”, хүүхдийн “Эрүүл шүд”, “Умайн хүзүүн хавдаргүй Монгол” хөтөлбөрүүдийг орон нутагт үргэлжлүүлэн хэрэгжүүлнэ.

1.3. Боловсрол

1.3.1. Сургуулийн хүүхдийн дотуур байрны өрөгтгөл барьна

1.3.2. Хүүхэд бүрийг сургуулийн өмнөх боловсролд хамруулж, бүлэг дүүргэлтийг стандартын түвшинд хүргэнэ.

1.3.3. Бага, дунд боловсролын чанарыг дээшлүүлж, сургалтын хөтөлбөр, агуулга, арга зүйд монголын түүх, хэл, соёл, үндэсний өв уламжлал, зан заншил, эх оронч сэтгэлгээ, хувь хүний хөгжил, төлөвшил, хос хэл, хүн төрөлхтний нийтлэг үнэт зүйлийг тусган хэрэгжүүлж, хүүхдийн өөрийнх нь авьяаст тулгуурлан хүүхдийг хөгжүүлж, амьдралын зөв дадалд сургана.

1.3.4. Цэцэрлэг, сургуулийн орчныг бүрэн камержуулж, хүүхдийн аюулгүй, таатай суралцах орчныг бүрдүүлнэ.

1.3.5. Баянмөнх сумын Ерөнхий боловсролын сургуулийн хичээлийн байрны барилгын өргөтгөл барьж байгуулна.

1.4. Халамж, хөдөлмөр эрхлэлт

1.4.1. Иргэдийг хөдөлмөрийн зах зээл дэх эрэлт хэрэгцээнд нийцсэн мэргэжлээр мэргэжлийн сургалтад хамруулан бүтээмжтэй, зохистой ажлын байрыг бий болгох замаар, хүн амын бүлэг бүрийн онцлогт нийцсэн хөдөлмөр эрхлэлтийг нэмэгдүүлж ажилтай, орлоготой болгож, ядуурлын түвшинг бууруулна.

1.4.2. Албан бус хөдөлмөр эрхлэлтийн бүртгэл, мэдээллийг сайжруулж, оюуны хөдөлмөрийг дэмжсэн цахим, зайн ажлын байрыг дэмжиж хөгжүүлнэ.

1.4.3. Төрийн байгууллагуудын нэрэмжит Ахмадын өдөрлөгийг уламжлал болгон явуулна.

1.4.4. Ахмад настны чөлөөт цагаа үр дүнтэй өнгөрүүлэх, мэдээлэл авах, хөгжих боломжийг бүрдүүлэх хөгжлийн төвүүдийн үйл ажиллагааг тогтмолжуулна

1.5. Үндэсний бахархал, өв соёл, спорт

1.5.1. Орон нутгийн өмчийн соёлын байгууллагын барилга байгууламж, хөдлөх хөрөнгийн ашиглалтыг сайжруулна.

1.5.2. Иргэд идэвхтэй хөдөлгөөн хийх, уулын болон явган аялал, хөдөлгөөнт дасгал, дугуйн спорт зэрэг нийтийн биеийн тамирын төрлүүдийг дэмжиж, хамрах хүрээг өргөжүүлнэ.

1.6. Хүүхэд, гэр бүлийн хөгжил

1.6.1. Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх аймгийн хөтөлбөр боловсруулан хэрэгжүүлнэ.

1.6.2. Хүүхэд гэр бүлд үзүүлэх хөгжлийн үйлчилгээг төрийн бус байгууллагаар гүйцэтгүүлэн, нийт хүүхэд гэр бүлийн 50 хувьд үйлчилгээ үзүүлнэ.

1.6.3. Гэр бүл, хүүхдэд сургалт хөгжлийн үйлчилгээ үзүүлдэг сургалтын баазтай болно

1.6.4. Гэр бүлийн хүчирхийллийг бууруулж, хүчирхийллийг үл тэвчих хандлагыг бий болгох нөлөөллийн арга хэмжээг хэрэгжүүлнэ

ХОЁР. ЭДИЙН ЗАСГИЙН БОДЛОГО

2.1. Хөдөө аж ахуй

2.1.1. Малын гаралтай түүхий эд бэлтгэх, боловсруулах үйлдвэрлэл эрхлэх загвар хоршоодод дэмжлэг үзүүлэх

2.1.2. Мал амьтнаас хүнд халдвартадаг халдварт өвчний хяналт, сэргийлэлт, яаралтай хариу арга хэмжээний бэлэн байдлыг хангах дэд төвийг байгуулна

2.1.3. Малын тоог чанарт шилжүүлэх, ашиг шимиийг нэмэгдүүлэх, эрчимжсэн мал аж ахуйг дэмжих, "Монгол мал-II" арга хэмжээг сумандаа хэрэгжүүлнэ.

2.1.4. "Шинэ хоршоо" хөдөлгөөнийг сумын хэмжээнд өрнүүлж, хоршоолохыг дэмжинэ.

2.1.5. Малчид хоршоолох замаар мах, сүү, арьс шир боловсруулах цех байгуулах, ажлын байрыг сум бүрт нэмэгдүүлэх бодлого баримтална.

2.2. Аялал жуулчлал

2.2.1. Аялал жуулчлалын ач холбогдол бүхий газруудыг google тар дээр байршуулах мэргэжлийн байгууллагатай хамтран ажиллана

2.2.2. Нутгийн иргэдэд түшиглэсэн, нүүдэлчин соёлыг харуулсан аялал жуулчлалыг хөгжүүлэх, чадавхижуулах, бүтээгдэхүүн үйлчилгээг нэмэгдүүлнэ.

.2.3. Дэд бүтцийн сүлжээ

2.3.1. Эрчим хүчний төсөл

2.3.1.1. Шинэ суурьшилын бүсрүү цахилгааны эх үүсвэрийг холбоно.

2.3.2. Автозам

2.3.2.1. Бор-Өндөр- Дархан- Баянмөнх- Чингис хот чиглэлийн хатуу хучилттай зам

ГУРАВ.НОГООН ХӨГЖЛИЙН БОДЛОГО

3.1. Эвдрэлд орсон, бохирдсон газрыг нөхөн сэргээх, газрын доройтол, цөлжилтөөс сэргийлж, хөрсний үржил шимийг нэмэгдүүлэхэд шинэ дэвшилтэт арга замыг тодорхойлж хэрэгжүүлнэ

ДӨРӨВ. ИРГЭДИЙН ОРОЛЦООНД ТУЛГУУРЛАСАН ЗАСАГЛАЛЫН БОДЛОГО

4.1. Зайлшгүй шаардлагатай асуудлаар хяналт шалгалт хийх “НЭЭЛТТЭЙ СОНСГОЛ”-ыг тогтмол зохион байгуулж иргэдийн мэдэх эрхийг хангана.

4.2. Багш, эмч, төрийн албан хаагчдын ажлын бодит үнэлэмжийг нэмэгдүүлж, ажлын хариуцлага, үр дүнг сайжруулна.

4.3. Төрийн түрэсийн орон сууцны хүртээмжийг нэмэгдүүлж, гурваас дээш жил үр бүтээлтэй ажиллаж буй төрийн албан хаагчдын цалин хөлсөнд нийцсэн ипотекийн зээл олгох бодлого баримтална.

4.4. Төрийн албан хаагч ажил үүргээ гүйцэтгэхдээ танил талдаа давуу тал олгохгүй байх, явцуу сонирхол, намын харьяллаар иргэдэд ялгавартай хандахгүй байх зарчмыг бүрэн хэвшүүлнэ.

4.5. Тендер сонгон шалгаруулалт, газар олголт, орон нутгийн эд хөрөнгийн дуудлага худалдааг ил тод нээлттэй зохион байгуулах, асуудал маргаангүй шийдвэрлэх бүх боломжийг бий болгох, хариуцлагажуулна.

4.6. Төрийн албан хаагчдын нийгмийн баталгааг хангах “Асуудлаас шийдэлд” дэд хөтөлбөрийг боловсруулж хэрэгжүүлнэ.

4.7. Орон нутгийн төсвөөс санхүүждэг төрийн байгууллагад ажиллагсдад орон нутгийн нэмэгдлийг нэмэгдүүлэн олгоно.

4.8. Баянмөнх суманд камержуулалтын системийг бүрэн нэвтрүүлнэ.

4.9. Төрийн үйлчилгээнд процессын дахин инженерчлэл хийх ажлыг үргэлжлүүлэн шат дамжлагыг бууруулж, иргэд, бизнест төвөггүй, хялбар үйлчилгээг үзүүлнэ.

ТАВ. ОРОН НУТГИЙН ХӨГЖЛИЙН БОДЛОГО

5.1. Баянмөнх суманд үүрэн телефоныг сүлжээг өргөтгөнө.

5.2. Төрийн байгууллагын эд хөрөнгийн ашиглалт, бүртгэл, хамгаалалтын байдалд үнэлэлт дүгнэлт өгөх, холбогдох арга хэмжээ, хариуцлага тооцож ажиллана.

